

Боржигин чуулгын даргын 2019 оны
09 сарын 12 ны өдрийн
А/СС.тоот тушаалын...1...-р хавсралт

ЗААЛ ТАНХИМ, ДЭЛГЭЦ, ХӨГЖИМ ТЕХНИК, ТАЙЗ КАРКАЗ, ГЭРЭЛ ТҮРЭЭСЛЭХ ЖУРАМ

НЭГ. ЗОРИЛГО

Мэргэжлийн урлагийн байгууллага нь өөрийн орлогыг бүрдүүлэх, Аж ахуйн нэгж, албан байгууллага, иргэдэд үйл ажиллагаа, арга хэмжээнд нь дэмжлэг үзүүлэхэд оршино.

ХОЁР. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Чуулгын үзэгчдийн заал болон анги танхим, эд материал, зөөврийн тайз, гэрэл, карказ дэлгэц, хөгжим техник хэрэгсэлийг ашиглуулах тохиолдолд зохих зөвшөөрлийн дагуу сар, өдрийн ажлын хувиарт тусгуулан үйл ажиллагаа зохион байгуулагч тал /байгууллага, хувь хүн/ гэрээ үйлдэж доорхи үнэ тарифыг мөрдлөг болгоно.

ГУРАВ. ТҮРЭЭСЛЭГЧИЙН ҮҮРЭГ

- 3.1 Түрээслэгч нь үйл ажиллагаа болох хугацаа, шаардлагатай заал танхим, тоног төхөөрөмжийн хүсэлт гарган байгууллагын даргын зөвшөөрөл авна.
- 3.2 Түрээслэгч зөвшөөрөгдсөн тохиолдолд чуулгын маркетингийн менежертэй доорхи үнэ тарифын дагуу үйл ажиллагааны цаг минут, тоо ширхэгийг тодорхой заасан гэрээ хийн гэрээний дагуу үйлчилгээний төлбөрийг хугацаанд нь төлөх
- 3.3 Түрээслэгч нь хугацааг хатуу баримтлан, түрээсийн үйлчилгээний үед чанартай уран бүтээлээр үйлчлэх, байгууллагын эд хөрөнгө, тоног төхөөрөмжид хохирхол учруулсан бол гарсан хохиролыг барагдуулна.
- 3.4 Түрээслэгчийн тоглолт, үзвэр үйлчилгээний зохион байгуулалттай холбоотой гарсан гомдлыг түрээслүүлэгч тал хариуцахгүй болно.

ДӨРӨВ. ТҮРЭЭСЛҮҮЛЭГЧИЙН ҮҮРЭГ

- 4.1 Түрээслэгч талын хүсэлтийн дагуу зохих зөвшөөрөлийг олгоно.
- 4.2 Түрээслэгчийн хүсэлтийн дагуу тоглолт, үзвэр үйлчилгээ, үйл ажиллагааг ажлын хуваарьт тусган гэрээг зохих үнэ тарифын дагуу цаг хугацаанд нь хийх
- 4.3 Түрээслүүлэгч нь гэрээний хугацаанд соёлтой, чанартай, зохион байгуулалттайгаар үйлчилгээ үзүүлэх